



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2022.09.26 № ЦМ-7/138 .

танай 2022.08.30 -ны № 22/809 -т

Хаяг, байршлын өөрчлөлтийг  
бүртгэсэн тухай

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг болон Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 6.2 дахь хэсгийн дагуу танай 12 дугаар салбарын хаяг байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг хянаж, “Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, 4-р хороолол, 20-р байр, 75 тоот” хаягт байрлаж байсныг “Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уурхайчин баг, Чандмань төв 2 давхарт, 209 тоот” гэж шинэчлэн бүртгэсэн болно.

Хаягийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн салбарын гэрчилгээ, Санхүүгийн зохицуулах хорооны нэгжийн зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад тэмдэглүүлж хуулбарыг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 10 хоногийн дотор ирүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын хаяг байршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор харилцагч, үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй байх талаар анхаарч ажиллана уу.

